



**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН  
БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ  
ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ**

**УЛААНБААТАР ХОТ 2023 ОН**

# АГУУЛГА

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

#### НЭГ. УДИРТГАЛ

ХУРААНГУЙ ҮР ДҮН .....	5
------------------------	---

#### ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1. Судалгааны арга зүй .....	8
2.2. Судалгааны түүврийн дизайн, түүвэрлэлт .....	9
2.3. Мэдээлэл цуглуулсан арга зүй .....	12
2.4. Судалгааны арга зүй .....	12
2.5. Мэдээлэл цуглуулалт, өгөгдөл боловсруулалт .....	14

#### ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл .....	18
3.2. Үйлчилгээний чанар, найдвартай үр дүнтэй байдал .....	20
3.3. Үйлчилгээний хүртээмж, ил тод байдал .....	28
3.4. Албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй .....	35
3.5. Үйлчилгээ үзүүлж буй орчин нөхцөлийн тав тухтай байдал, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ .....	37

#### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

#### ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгааны арга зүй, дараалал

Хүснэгт 2. Иргэд, олон нийтийн хандлагын судалгаа

Хүснэгт 3. Үнэлгээний тайлан боловсруулах дараалал

Хүснэгт 4. Үйлчилгээний чанар, найдвартай байдал

Хүснэгт 5. Үйлчилгээний хүртээмжтэй байдал

Хүснэгт 6. Мэдээллийн эх сурвалж

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Улсын хэмжээнд/
- Зураг 2. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Улаанбаатар хотын хэмжээнд/
- Зураг 3. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Хөвсгөл аймгийн хэмжээнд/
- Зураг 4. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Өвөрхангай аймгийн хэмжээнд/
- Зураг 5. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа
- Зураг 6. Иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн байгууллагад итгэх итгэл
- Зураг 7. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
- Зураг 8. 2023 оны хагас жилийн байдлаар үр дүнтэй ажлын хураангуй
- Зураг 9. Ил тод байдлын шалгуур
- Зураг 10. Ил тод байдлын үнэлгээ
- Зураг 11. Гомдол, мэдээллийн өсөлт

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Судалгаанд оролцогчдын насны ангилал
- График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал
- График 3. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал
- График 4. Үйлчилгээний чанар, найдвартай байдал
- График 5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх талаар
- График 6. Урьдчилан сэргийлэх чиглэлийн үр дүнгийн байдал
- График 7. Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх байдал
- График 8. 102-ын дуудлага хүлээн авах утастай холбоотой байдал
- График 9. Амьдарч буй орчны амар тайван байдлын илэрхийлэл
- График 10. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ
- График 11. Үйлчилгээний хүртээмж
- График 12. ЦБ-аар асуудал шийдвэрлүүлсэн байдал
- График 13. ЦБ-аас үйлчилгээ авсан хэлбэр, давтамж
- График 14. Иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалж, хувиар
- График 15. Мэдээллийн хүртээмж
- График 16. Алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ
- График 17. Санал, гомдолтой иргэдийн хувь
- График 18. Байгууллагын орчин нөхцөл, тав тухын үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ
- График 19. Үнэлгээний нийт дүн
- График 20. Сэтгэл ханамжийг удирдагч хүчин зүйлсийн шинжилгээ
- График 21. GAP шинжилгээ



# УДИРТГАЛ

Монгол Улсын хөгжлийн нэн чухал үе буюу төрийн байгууллагын гүйцэтгэл үр дүн, хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж буй энэ цаг үед төрийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээнд иргэдийн оролцоог хангах явдал зайлшгүй билээ.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь чиг үүргийн дагуу иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлэхдээ Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан хүний эрх, шударга ёс, тэгш байдлыг ханган ажиллах үүрэг хүлээдэг.

Монгол Улсын Их Хурлаас хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2020 онд шинэчлэн баталж мөрдүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газраас хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийнн хэрэгжилтийг зохион байгуулах явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулан журамласан.

Журамд төрийн захиргааны байгууллагууд жил бүр үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр тусгасан нь дэлхийн улс орнуудын Засгийн газрын нэгэн адил сайн засаглал, хариуцлага, ил тод байдал, хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох талаар оролцогч талуудаас тавьж буй шахалт шаардлагад мэдрэмжтэй хандах болсны илэрхийлэл юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг удирдлага болгохыг заасан.

Иймд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлах, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд зөвлөмж гарган ажиллалаа.

“Ялангуй академи” төрийн бус байгууллага нь судалгаа, зөвлөх үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд судалгааны ажлын бүхий л үе шатанд ёс зүй, мэргэжлийн чиг баримжаатай байж, ESOMAR<sup>1</sup> ёс зүй код, өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, нийгмийн болон олон нийтийн санаа бодлын судалгааны ISO 20252:2019 олон улсын стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Энэ ажлыг гүйцэтгэхэд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлсэн Цагдаагийн ерөнхий газрын төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн алба хаагчдад талархалаа илэрхийлье.



# ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ



## ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

### 2.1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

#### СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” (цаашид “нийтлэг журам” гэх), Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”, Цагдаагийн ерөнхий газартай байгуулсан ажил гүйцэтгэх 2023/001 дугаартай гэрээ, Цагдаагийн ерөнхий газрын төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн даргын баталсан “Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлын удирдамж”-ыг тус тус үндэслэл болгов.

#### ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Үнэлгээний зорилго нь цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

Зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тодорхойлж үнэлгээ хийв. Үүнд:

- ❖ Бодлого, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх;
- ❖ Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах, судлах;
- ❖ Иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн үзүүлэх үйлчилгээг сайжруулах зөвлөмж өгөх.

#### ХИЙГДСЭН АЖЛУУД

“Ялангуй академи” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага нь судалгаа хийх бүхий л техник, программ хангамж, хүний нөөцийн чадамжтай бөгөөд судалгааны үе шатанд ёс зүй, мэргэжлийн чиг баримжаатай байж, Олон Улсын судалгааны стандартыг мөрдөн ажилладаг байгууллага юм.

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг нарийвчлан авч үзвэл дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

- ❖ Шинжлэх ухааны онолын үндэслэл, арга зүйн дагуу түүвэрлэлт хийх;

- ❖ Cluster sampling- Мужилсан (кластер) түүврийн аргаар түүврийн хамрах хүрээ, хэмжээг тодорхойлох; Эх олонлогийн шинж чанар ялгаатай байх тохиолдолд түүврийн хүрээ бэлтгэх, мэдээлэл цуглуулах зардлыг бууруулах зорилготой хэрэглэдэг түүврийн арга юм. Кластер түүврийн үед эх олонлогийг анхан шатны нэгж буюу 6 муж болгон хуваадаг. Түүврийн ямар ч аргаар анхан шатны нэгжийг сонгон авч болох бөгөөд түүвэрт сонгогдсон АШН-ийг бүхэлд нь судалж болно. Харин АШНийн хэмжээ нь хэтэрхий том бол түүнийг бүхэлд нь судлахын оронд түүний нэгжүүдээс хоёрдогч нэгжүүдийг түүвэрлэн судалж болно. Энэ тохиолдолд хоёр үе шаттай түүврийн аргыг хэрэглэж байна гэсэн үг;
- ❖ Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаар үйлчлүүлж буй хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг холбогдох стандартын дагуу боловсруулах;
- ❖ Асуулгыг мэргэжлийн программд оруулах, шалгах программыг бэлтгэх, турших;
- ❖ Computer-Assisted Personal Interview- Компьютерын тусламжтай ганцаарчилсан ярилцлага (CAPI): цахим асуулгын хуудас болон гар утас, таблет, зөөврийн компьютер гэх мэт хөдөлгөөнт төхөөрөмж ашиглан ярилцлага хийж, хариултыг бүртгэх арга юм. Үр дүнг статистик дүн шинжилгээний программаар уншиж болох форматаар шууд зохион байгуулж, мэдээллийг боловсруулах цагийг бодитой хэмнэн, зорилтот хэрэглэгчээс нүүр тулсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах;
- ❖ Мэдээлэл цуглуулалтыг бэлтгэгдсэн, туршлагатай судлаачдын тусламжтайгаар мэргэжлийн өндөр түвшинд хяналтын ажлыг хийх. Үүнд: түүврийн тархалтыг Global Positioning System- Глобал Байршлын Систем (GPS)-ээр хянах, судалгааны дата мэдээллийг аудио бичлэгтэй тулгах, хүндрэл бэрхшээлийн талаар дүн шинжилгээ хийх;
- ❖ Өгөгдлийг нэгтгэх, үр дүнг гаргах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгааны тайлан боловсруулах;
- ❖ Судалгааны эцсийн тайланг захиалагч талд хүлээлгэн өгөх.

## 2.2. ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВЭРЛЭЛТ

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг судлах зорилгоор Улаанбаатар хот, Хөвсгөл аймаг, Өвөрхангай аймгийн иргэдийг хамруулан, хэрэглэгчийн үнэлгээний удирдамжийг удирдлага болгон тус ажлыг гүйцэтгэв.

Судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллоор тооцсон. Үүнд:

$$n = (z^2 \times P_0 \times (1 - P_0) / e^2) \times Deff$$

- Z = Хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга
- P0 = Түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)
- Deff = Кластерийн нөлөө (*Тухайн түүврийн дизайны вариацийг энгийн санамсаргүй үеийн вариацитай харьцуулж тооцно.*)
- e = Алдааны хязгаар

Улаанбаатар хотын дүүргүүдээс 293, Хөвсгөл аймгаас 45, Өвөрхангай аймгаас 52 иргэд, алба хаагчдыг хамарсан нийт n=390 хүнээс судалгааг авч, үр дүнг гаргалаа.

Зураг 1. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Улсын хэмжээнд/

**СУДАЛГААНД ХАМРАГДСАН ИРГЭД**



Зураг 2. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Улаанбаатар хотын хэмжээнд/

Түүвэрт Улаанбаатар хотын 293 иргэн, алба хаагчид оролцсон.



Зураг 3. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Хөвсгөл аймгийн хэмжээнд/

Хөвсгөл аймгийн 45 иргэн, алба хаагчид уг судалгаанд хамрагдав.



Зураг 4. Судалгааны түүвэрлэлт, хамрах хүрээ /Өвөрхангай аймгийн хэмжээнд/

Өвөрхангай аймгийн 52 иргэн, алба хаагчид уг судалгаанд хамрагдав.



Байгууллагын хэмжээнд нийт 3 объектыг хамарсан 11 удаагийн ажиглалт, асуулгын хуудсын бүртгэл хийлгэсэн бөгөөд алба хаагчдаас [https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSeDOSKnBucdl2OU t M9uAMPaNe eQBgzj PDMi4OYeqOvAP1Q/viewform?fbclid=IwAR38VQlubgAJHq\\_OkDilcvXWIFFdgEDSzWhlB aG5WKcрApUIGJncJ55xWtg](https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSeDOSKnBucdl2OU t M9uAMPaNe eQBgzj PDMi4OYeqOvAP1Q/viewform?fbclid=IwAR38VQlubgAJHq_OkDilcvXWIFFdgEDSzWhlB aG5WKcрApUIGJncJ55xWtg) формоор асуумж судалгааг, 11 хүнээс ганцаарчилсан ярилцлага авав.

Стандартчилагдсан ярилцлагад хамрагдах үйлчлүүлэгч, албан хаагч дараах шалгуурыг хангасан байна:

- 18-аас дээш настай байх
- Судалгаа авч байх үед иргэн бол тухайн шатны байгууллагаас ямар нэгэн үйлчилгээ авсан байх, албан хаагч бол төрийн жинхэнэ албан хаагч байх гэсэн шалгуурыг тус тус баримталсан болно.

### 2.3. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН АРГА ЗҮЙ

Уг судалгааны хүрээнд нийгмийн судалгаанд хэрэглэгддэг олон улсын нийтлэг онол, арга зүй, тэргүүн туршлага, шинжлэх ухааны аргачлалд тулгуурлан, мөн холбогдох стандарт, дүрэм, журамд үндэслэн хэрэглэгчийн үнэлгээний арга зүйг боловсруулсан. Арга зүйг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- Захиалагчийн зүгээс судалгааны ажлын гэрээнд дурдсан ажилбар бүрийг бүрэн дэлгэрэнгүй түвшинд хамарсан байх;
- Олон улсын болон үндэсний түвшинд хэрэглэгдэж буй нийтлэг арга зүй, тэргүүн туршлагад үндэслэсэн байх, судалгааны үе шат тус бүрд ёс зүйн болон мэргэжлийн стандартуудыг дагаж мөрдөх;
- Шинжлэх ухааны болон практикийн үндэслэл, нотолгоотой, ач холбогдолтой арга зүйг сонгосон байх;
- Аргачлал, арга зүй, зохион байгуулалт нь эдийн засгийн болон ажлын эцсийн үр дүнгийн хувьд үр ашигтай байх зэрэг болно.

**Санал асуулгын агуулга:** Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг, бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ, чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээл бий эсэхийг тандахад чиглэсэн. Санал асуулгад дараах бүлэг асуулт багтсан байна. Үүнд:

1. Үйлчилгээний чанар болон найдвартай үр дүнтэй байдал;
2. Үйлчилгээний хүртээмжтэй, ил тод байдал;
3. Албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй;
4. Үйлчилгээ үзүүлж буй орчин нөхцөлийн тав тухтай байдал, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ.

Мөн мэдээллийг цуглуулахдаа цаасан санал асуулга болон цахим асуулга (google doc), real time-аар ажиглах, танадах, санаандгүй байдлаар ярилцах зэргээр энгийн хэлбэрээр танадах аргыг түлхүү ашиглалаа.

### 2.4. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан удирдамж, Цагдаагийн ерөнхий газартай байгуулсан гэрээ, ажлын удирдамж зэргийг удирдлага болгон судлаачид дараах дарааллаар үнэлгээний арга зүйг боловсруулсан.

## Хүснэгт 1. Судалгааны арга зүй, дараалал



Байгууллагын талаар иргэд, албан хаагчдын хандлагын судалгааг авахдаа судалгааны зорилгыг хангах зорилтуудыг дэвшүүлж, судалгааны ерөнхий мэдээлэл, сэтгэл ханамжийн байдал, иргэдэд үзүүлэх үйлчилгээний саад бэрхшээл болон үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалжийн ил тод, ойлгомжтой байдал зэргийг судалсан болно.

## Хүснэгт 2. Иргэд, олон нийтийн хандлагын судалгаа



Үнэлгээний тайланг боловсруулахдаа судалгааны дэлгэрэнгүй тайланг эмхэтгэл хэлбэрээр гаргах, хураангуй тайланг зурган хэлбэрээр гаргах зэргээр судлаачид ажиллаж, үр дүнгийн дүгнэлт, зөвлөмж гаргах, тайланд ашигласан материалыг эмхэтгэлд хавсаргах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### Хүснэгт 3. Үнэлгээний тайлан боловсруулах дараалал



## 2.5. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Улаанбаатар хот болон Хөвсгөл, Өвөрхангай аймагт санал асуулгын аргаар нийт 390 судалгаанд хамрагдагчаас анхдагч мэдээлэл, 11 хамрагдагчаас чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ганцаарчилсан ярилцлага, иргэн, алба хаагчийн төлөөллөөс бүрдсэн 2 фокус бүлгийн ярилцлага авсан.

Судлаачдад үнэлгээ судалгааны зорилгыг танилцуулж, санал асуулгыг хэрхэн бөглөх, асуултуудыг хэрхэн ойлгох талаар арга зүйн зааварчилгаа өгч, судалгааг явуулсан.

Тоон судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг мөн тус бүр 2 гишүүнтэй 2 баг, 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр шалгуур хангасан иргэнээс санал асуулгыг судлаач нэг бүрчлэн асууж, бөглөх зарчмаар хийж гүйцэтгэсэн.

Чанарын судалгааны мэдээллийг ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглаж цуглуулсан.

Мэдээлэл боловсруулахдаа мэдээлийг шалган кодлолт хийн оруулж, “Зах зээлийн, олон нийтийн санаа бодол, нийгмийн судалгаа, нэр томъёоны тайлбар толь,

үйлчилгээнд тавигдах шаардлага” MNS ISO 20252:2012 олон улсын стандартын дагуу зохих хяналт хийсэн.

Судалгааны баг уг ажлын судалгаанд хэрэглэгдэх арга зүй, дараалал, түүврийн дизайныг захиалагч байгууллагын удирдамжид тохируулан боловсруулж, үр дүнгийн нэгтгэл, оролцогчдын мэдээлэл, SPSS өгөгдөл зэргийг тус төрийн бус байгууллагын зөвлөх, доктор, профессорын удирдлага дор боловсруулан дараах үйл ажиллагааны зураглалын дагуу ажиллалаа.







# ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

## ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

### 3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Санал асуулгад нийт 390 иргэн хамрагдснаас 92.0 хувь нь Улаанбаатар хотоос, 8.0 хувь нь орон нутгаас хамрагдсан. Хүйсийн хувьд оролцогчдын 148 нь буюу 37.9 хувь нь эрэгтэйчүүд, харин 242 нь буюу 62.1 хувь нь эмэгтэйчүүд байв.

Зураг 5. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа



Судалгаанд оролцогч нийт 390 хүний насыг ангилан авч үзвэл 24 наснаас доош ангилалд хамаарах 34, 25-34 насны ангилалд хамаарах 159, 35-44 насны ангилалд хамаарах 130, 45-54 насны ангилалд хамаарах 43, 55 наснаас дээш насны ангилалд хамаарах 24 хүн тус тус байна.

График 1. Судалгаанд оролцогчдын насны ангилал




Боловсролын байдлыг нь авч үзвэл нийт оролцогчдын 41 хувь нь дээд, 27 хувь нь бүрэн дунд, 25 хувь нь бүрэн бус дунд, 4 хувь нь бага боловсролтой байсан ба түүвэрт хамрагдсан оролцогчдоос боловсролгүй оролцогч 3% байв.

График 2. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал



Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл 167 нь буюу 34.8 хувь нь төрийн байгууллагад ажилладаг, 93 нь буюу 33.8 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 63 нь буюу 17.3 хувь нь хувийн байгууллагад ажилладаг, 37 нь буюу 9.6 хувь нь төрийн бус байгууллагад ажилладаг, 32 нь буюу 8.3 хувь нь оюутан, 9 нь буюу 1.9 хувь нь олон улсын байгууллагад ажилладаг, 6 нь буюу 1.3 хувь нь тэтгэвэрт гарсан байдалтай байна.

График 3. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал



## 3.2 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, НАЙДВАРТАЙ, ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛ

### 3.2.1. Үйлчилгээний чанар, найдвартай байдал

Судалгаанд оролцсон иргэдээс Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйлчилгээний чанарыг үнэлүүлж, дүнг багцлан нэгтгэлээ. Ингэхдээ 1 оноо - Маш муу, 2 оноо – Муу, 3 оноо – Дунд зэрэг, 4 оноо – Сайн, 5 оноо –Маш сайн гэсэн байдлаар үнэлүүлэн дундаж утгыг тооцон гаргалаа.

#### Хүснэгт 4. Үйлчилгээний чанар, найдвартай байдал

Үзүүлэлтүүд	мэдэхгүй	маш муу	муу	дунд	сайн	маш сайн
	0	1	2	3	4	5
Асуудлыг тань нэг удаагийн хандалтаар шийдэж өгөх эрмэлзэл	56	33	53	79	101	68
Алба хаагчдын мэдлэг, ур чадвар	49	3	5	223	97	13
Алба хаагчдын ажлын бүтээмж	8	2	1	15	278	86
Хариу мэдээлэх байдал	5	0	0	0	212	173
Санал, гомдлоо илэрхийлэх нээлттэй байдал	0	0	0	84	204	102

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, найдвартай байдлыг тодорхойлох үүднээс нийт 5 асуулт бүхий асуулгыг 390 иргэнээс авч үр дүнг нэгтгэлээ. Ингэхдээ үр дүнг **Маш муу, Муу, Дунд зэрэг, Сайн, Маш сайн** ангиллаар нэгтгэн гаргахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тус байгууллагын алба хаагчид асуудлыг тань нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг эрмэлзсэн үү гэсэн асуултад маш муу-33, муу-53, дунд зэрэг-79, сайн-101, маш сайн-68 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 56 хүн хариулжээ. Энэ нь байгууллагын шуурхай, хүнд сурталгүй байдлыг илэрхийлж байна.

- Алба хаагчдын мэдлэг, ур чадвар ямар байсан бэ? гэсэн асуултад маш муу-3 муу-5, дунд зэрэг-223, сайн-97, маш сайн-13 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 49 хүн хариулжээ. Энэ нь ажилтны боловсрол, мэдлэгт сэтгэл ханамжтай байгааг илэрхийлж байна.


-Алба хаагчдын ажлын бүтээмж ямар байсан бэ? гэсэн асуултад маш муу-2, муу-1, дунд зэрэг-15, сайн-278, маш сайн-86 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 8 хүн хариулжээ. Энэ нь байгууллагын албан хаагчдын ажилдаа хандах хандлагад сэтгэл өндөр байгааг илэрхийлж байна.

-Таны асуудлын хариуг эргэн мэдээлсэн үү? гэсэн асуултад сайн-212, маш сайн-173 гэж хариулсан бол мэдэхгүй гэж 5 хүн, харин маш муу, муу, дунд зэрэг гэсэн

ангилалд үнэлсэн оролцогч байхгүй байна. Энэ нь байгууллагын албан хаагчдын харилцаа хандлагад дунд зэрэг сэтгэл ханамжтай байгааг илэрхийлж байна.

- Танд санал, гомдлоо илэрхийлэх байдал нээлттэй байсан уу? гэсэн асуултад дунд зэрэг- 84, сайн-204, маш сайн-102 гэж хүн хариулсан бол маш муу, муу, мэдэхгүй гэж хариулсан оролцогч байхгүй байна. Энэ нь байгууллагын албан хаагчдын шударга байдалд сэтгэл өндөр байгааг илэрхийлж байна.

**График 4. Үйлчилгээний чанар, найдвартай байдал**



Иргэдээр Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гарсаныг доорх байдлаар тандаж үнэлүүлэхэд чанарын өөрчлөлт гарч үйл ажиллагаа нь сайжирсан гэж 51 хувь нь, огт өөрчлөгдөөгүй гэж 25 хувь нь, муудсан гэж 4 хувь нь, мэдэхгүй гэж 20 хувь нь тус тус хариулсан байна. Судалгаанаас үр дүнгээс дүгнэхэд тухай иргэний хувьд (хэзээ үйлчлүүлсэнийг асуух боломжгүй) цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг аль цаг хугацаатай харьцуулж байгааг мэдэхгүй ч үйл ажиллагаа нь сайжирч, чанарын өөрчлөлт, ахиц илэрч байгаад иргэд сэтгэл хангалуун байна.

График 5. Үйлчилгээний чанар, найдвартай байдал

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫН ӨӨРЧЛӨЛТ**



Үйлчилгээний чанар, найдвартай, үр дүнтэй байдлыг ажилтнуудын хариуцлагатай байдал, ажлын бүтээмж, ур чадвар, хүнд сурталгүй байдал, үйл ажиллагааны чанарт өөрчлөлт гарсан байдал зэргийг 4-5 дэд агуулгын хүрээнд үнэлүүллээ.

### 3.2.2. Үйлчилгээний үр дүнтэй байдал

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний үр дүнтэй байдлыг үнэлэхдээ хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудыг 2023 оны хагас жилийн байдлаар авч үзэн, дүн шинжилгээ хийсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд 2023 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.


**Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар /2023 оны хагас жилийн байдлаар/**

**1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд нэгдсэн 14, хэсэгчилсэн 193, нийт 207 ажил, арга хэмжээг зохион байгуулсан байна.

Зохион байгуулсан ажлын үр дүн ямар байгааг тус судалгааны ажлаар иргэдээр үнэлүүлэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн, мөн гэмт хэрэг илрүүлэлтийн үр дүн доорх байдлаар гарсан байна.

Иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх тал дээр Цагдаагийн байгууллагад итгэх итгэл сайн байгаа нь 43.1 хувь, дунд зэрэг итгэдэг нь 42.7 хувь, маш их итгэдэг 6.9 хувь, огт итгэдэггүй 5.3 хувь, ер нь итгэдэггүй 2.0 хувьтай байна.

Зураг 6. Иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн байгууллагад итгэх итгэл



Цагдаагийн албан хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх тал дээр хэр үр дүнтэй ажилладаг гэж үздэг талаар асуухад  $\sum 197$  нь сайн гэж үздэг, 148 нь дунд зэрэг гэж үздэг, харин  $\sum 45$  нь муу гэж үздэг байна.

Энэ нь  $\sum = 197 * 100\% / 390$  судалгаанд оролцогч нийт иргэдийн 50.6% нь сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.


График 5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх талаар

**ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИЛРҮҮЛЭХ ТАЛ ДЭЭР ХЭР ҮР ДҮНТЭЙ АЖИЛЛАДАГ ТАЛААР**





График 6. Урьдчилан сэргийлэх чиглэлийн үр дүнгийн байдал



Эндээс дүгнэхэд иргэд цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх итгэл нь хэвийн буюу дунд зэрэг  $\Sigma 85.8, 50.6$  хувьтай байна гэж дүгнэж болохоор байна.

**2.Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:** “Сар шинэ 2023”, “Нөмрөг”, “Хуурамч мөнгө”, “Хуурамч акц 2023”, “Шалгалт”, “Илрүүлэлт, шийдвэрлэлт-1”, “Виз”, “Шийдвэрлэлт”, “Илрүүлэлт, шийдвэрлэлт, хамтын ажиллагаа”, “Цахим орчинд хүний эрхийг хамгаалах”, “Хяналт-2023”, “Нуугдмал” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил буурч, хэргийн илрүүлэлт нэмэгдсэн байна.

График 7. Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх байдал

ИРГЭД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ БАЙДАЛ




График 8. 102-ын дуудлага хүлээн авах утастай холбоотой байдал



**3.Экологийн цагдаагийн албаны чиглэлээр:** Улсын хэмжээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 792 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс бүртгэгдсэн гомдол 175 буюу 18.1 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.


**4.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд давхардсан тоогоор 31206 офицер, 54032 цагдаа, нийт 85238 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 73979 объект, 453772 хүн, 282414 тээврийн хэрэгсэл шалгаж, гэмт хэрэг зөрчлийн 175271 дуудлага, мэдээллийг шалгаж, 143 хэрэг, 46804 зөрчлийг илрүүлэн 222 хуулийн этгээд, 49514 иргэнийг 1.374.570.761 төгрөгийн торгууль ноогдуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 627, түр саатуулсан тээврийн хэрэгсэл 292, 1698 хүнийг эрүүлжүүлж, 10.007 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 761 хүнийг шүүхээр баривчлуулж ажилласан байна.

Улсын хэмжээнд нийт 435 /нийтийг хамарсан арга хэмжээ 295, жагсаал, цуглааны хэлбэр агуулсан 140/ удаагийн арга хэмжээ зохион байгуулагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Эргүүл-2”, “Эргүүл-3”, “Эргүүл-Хяналт”, “Үзлэг-шалгалт”, “Төгсөлт” зэрэг тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласнаар Баянзүрх дүүрэгт иргэд, байгууллагаас ирүүлсэн дуудлага, мэдээлэл 707 нэгжээр буюу 4.7 хувиар, үүнээс зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээлэл 340 нэгжээр буюу 2.7 хувиар, гэмт хэргийн шинжтэй дуудлага мэдээлэл 68 нэгжээр буюу 12.4 хувиар, халаасны хулгай 83 нэгжээр буюу 18.7 хувиар тус тус буурсан байна.

График 9. Амьдарч буй орчны амар тайван байдлын илэрхийлэл

**АМЬДАРЧ БУЙ ГАЗАРТ АМГАЛАН ТАЙВАН АМЬДРАХ  
НӨХЦӨЛ БҮРДСЭН БАЙДАЛ**



**5.Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр:** Улсын хэмжээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 9223 зам тээврийн осол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар буурсан байна. Нийт ослын 7877 буюу 85.4 хувь нийслэлд, 1346 буюу 14.6 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Цагдаагийн байгууллагад хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 464 бүртгэгдэж, 90 хүн нас барж, 385 хүн гэмтсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 4.5 хувиар, гэмтсэн 6.6 хувиар, нас барсан хүн 15.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Мөн 464 гэмт хэргээс 80 хэрэгт мөрдөн байцаалтын хэрэг, 384 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгасан байна.

Зам тээврийн ослын улмаас нийт 17,020,055,163 төгрөгийн хохирол учирч үүнээс 15,858,419,032 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 93.1 хувьтай байна.

Гудамж замын хяналт, шалгалтаар нийт 1.157.037 зөрчил илрүүлж, үүнээс замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр 1.135.627, төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт 10251, нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн 11159 зөрчлийг шалган шийдвэрлэлээ. Зам хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр илрүүлсэн зөрчлийн 823672 буюу 72.5 хувь нь нийслэлд, 311955 буюу 27.6 хувь нь орон нутагт илрүүлсэн байна. Зөрчил гаргасан 1083041 хүнийг 32,333,980,500 төгрөгөөр торгож, 2804 хүнийг баривчилж, 13690 хүнийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж шийдвэрлэжээ.

**6.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санг 34 төрлийн мэдээллээр баяжуулж, сар бүр 24 нэр төрлийн нийт 72 статистик, мэдээ тайланг боловсруулан гаргаж, цагдаагийн байгууллагын дотоод /guide.police.gov/


сүлжээ, гадаад /police.gov.mn/, /information.police.gov.mn/ цахим сайтуудад байршуулсан байна.

Цахим орчин /вэбсайт, facebook, twitter/-д нийтлэгдсэн мэдээ, мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх “Кудос” системийг нэвтрүүлснээр цахим орчинд нийтлэгдсэн мэдээ, мэдээлэлд иргэдийн эерэг, сөрөг хандлагыг тодорхойлох боломжтой болжээ.

Зураг 7. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа


## ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА (2023 ОНЫ ХАГАС ЖИЛ)

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас гадаад орны цагдаа, хууль сахиулах, олон улсын байгууллагуудын төлөөлөлтэй уулзах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад хамтын ажиллагаа, хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар ярилцаж, цаашид хамтын ажиллагааны хүрээнд 8 орны 10 удаагийн албан айлчлал, 9 орны 20 удаагийн албан уулзалтыг тус тус зохион байгуулсан байна.



Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны хагас жилийн тайланд дурдсанчлан үндсэн 6 чиг үүргийг онцлон, гарсан гол үр дүнг дараах графикаар харууллаа.

График 10. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ



Мөн хагас жилийн байдлаар гүйцэтгэсэн ажлын мэдээлэл болон статистикт дүгнэлт хийн, хураангуй байдлаар доорх зургаар харуулж байна.

Зураг 8. 2023 оны хагас жилийн байдлаар үр дүнтэй ажлын хураангуй



Уг дэд үзүүлэлтийн хүрээнд үйлчилгээний үр дүнтэй байдлыг үнэлэхдээ Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ үр дүнтэй хийж хэрэгжүүлсэн байдалд үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэлээ. Байгууллагын хэмжээнд 2023 онд үндсэн чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын статистик үр дүн дээшилсэн үзүүлэлттэй байна.

### 3.3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ИЛ ТОД БАЙДАЛ

#### 3.3.1. Үйлчилгээний хүртээмжтэй байдал

Хүснэгт 5. Үйлчилгээний хүртээмжтэй байдал

Үзүүлэлтүүд	мэдэхгүй	маш муу	муу	дунд	сайн	маш сайн
	0	1	2	3	4	5
Үйлчилгээний ачааллын хэвийн байдал	67	30	43	84	98	68
Үйлчилгээг авах, ямар материал бүрдүүлэх талаарх энгийн, ойлгомжтой байдал	38	3	3	233	67	46
Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдал	8	2	8	31	261	80
Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг авах боломжтой байдал	5	0	0	14	212	159

Цагдаагийн байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжтэй байдлыг тодорхойлох үүднээс нийт 7 асуулт бүхий асуулгыг 390 иргэнээс авч үр дүнг нэгтгэлээ. Ингэхдээ үр дүнг **Маш муу, Муу; Дунд зэрэг, Сайн, Маш сайн** гэсэн 3 утгаар авч үзэн гаргахад дараах байдалтай байна. Үүнд:

-Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлэхэд ачаалал хэр байсан талаар асуухад нийт оролцогчдын  $\Sigma 73$  нь тааруу үнэлгээ өгсөн бол 184 нь дунд зэрэг  $\Sigma 166$  нь сайн үнэлгээ, харин 67 нь мэдэхгүй гэсэн үнэлгээ өгсөн байна. Энэ нь Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлэхэд хэт их ачаалалтай гэж судлагдсан байдлын статистикээс дээшилсэн, эерэг үр дүн гарсан үзүүлэлт байна.

-Тус байгууллагын үйлчилгээг авахад хэрэгцээтэй материал нь энгийн, ойлгомжтой байсан талаар асуухад  $\Sigma 6$  нь тааруу үнэлгээ өгсөн бол 233 нь дунд зэрэг  $\Sigma 113$  нь сайн, харин 38 нь мэдэхгүй гэж хариулжээ. Энэ нь байгууллагын үйл ажиллагаа нь иргэдэд харьцангуй ойлгомжтой, тодорхой байдгийн илрэл гэж үзэв.

-Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдлыг үнэлүүлэхэд  $\Sigma 10$  нь сэтгэл дундуур, 31 нь үйлчилгээ авахад боломжийн  $\Sigma 341$  нь сэтгэл ханамжтай байгаагаар илэрхийлсэн. Харин 8 нь мэдэхгүй гэж хариулсан байна. Иргэдийн сэтгэл ханамж өндөр байгааг илэрхийлж байна.

-Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг авах боломжтой байдлыг үнэлүүлэхэд 14 нь дунд зэрэг  $\Sigma 371$  нь боломжийн, харин 5 нь мэдэхгүй гэжээ. Сэтгэл ханамжгүй буюу муу үнэлгээ өгсөн оролцогч байхгүй байна.

График 11. Үйлчилгээний хүртээмж






Үйлчлүүлж байгаа иргэдээс Цагдаагийн байгууллагатай холбогдсон асуудлаа шийдвэрлүүлсэн байдлыг судлан үзэхэд бүрэн шийдвэрлэсэн гэх 33.1 хувь, шийдвэрлэх шатанд байгаа 21.1 хувь, ямар ч гэсэн шийдвэрлэсэн гэх хандлагатай 19.0 хувь, шийдвэрлээгүй гэх 11.2 хувь тус тус байна.

Мөн ямар шалтгааны улмаас цагдаагийн байгууллагатай холбогдож байгааг тодруулсан судалгааны үр дүнг дараах графикаас харж болно.

График 12. ЦБ-аар асуудал шийдвэрлүүлсэн байдал




Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж байсан иргэдийн давтамж болон үйлчлүүлсэн үйлчилгээний төрлөөр нь судлан үзсэн.

Эд хөрөнгө, эд зүйлсээ хулгайд алдсан шалтгааны улмаас Цагдаагийн байгууллагатай холбогдон үйлчлүүлж байгаа иргэд түлхүү байгааг дараах зургаас харж болно.

Цагдаагийн байгууллагын үйлчилгээ авах шаардлагатай болох үед аль хэлбэрээр дуудлага өгч холбогддог талаар судлан үзэхэд судалгаанд оролцсон иргэдийн 65 хувь нь утсаар, 31 хувь нь өөрийн биеэр гэж үлдсэн хувь нь бусад хэлбэрээр ханддаг байна.

График 13. ЦБ-аас үйлчилгээ авсан хэлбэр, давтамж



Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй байдлыг иргэд, олон нийтийн үнэлгээнээс дүгнэхэд тус байгууллагын үйлчилгээ хүртээмжтэй, шуурхай, найдвартай байдал сайжирсан гэж илэрхийлсэн байна.

### Цагдаагийн байгууллагатай холбоотой мэдээлэл авч буй эх сурвалж

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын олон нийттэй харилцах болон мэдээлэл сурталчилгааны ажлын байдлыг нэг талаас олон нийтийн мэдээллийн хэрэгцээ, хайлтаар тодорхойлж болох бол нөгөө талаас Цагдаагийн байгууллагын ил тод байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж буй байдлыг харж болно.

Иргэд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагатай холбоотой мэдээллийг ямар эх сурвалжаар голлон авч байгаа болохыг дараах зургаар дэлгэрүүлэн харууллаа.



График 14. Иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалж, хувиар



Иргэдийн ихэвчлэн мэдээлэл авахыг хүсэж буй эх сурвалжаар интернет, телевиз гэсэн мэдээллийн эх сурвалжууд нэрлэгдэж байна. Энэ нь мэдээлэл ихэвчлэн авдаг болон авахыг хүсэж буй сувгууд хоорондоо шууд хамааралтай байгааг илтгэж буй тул эдгээр мэдээлэл түгээх эх сурвалжуудыг түлхүү ашиглах нь үр дүнтэй.

Дээрх дүрсээс харахад иргэд одоогийн нөхцөлд утасны мессеж болон лавлах утсаар мэдээлэл аваад байдаггүй ч цаашид авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн хувь өссөн байна. Мэдээлэл авдаг хэлбэр болон авахыг хүссэн эх сурвалжуудыг үзүүлж буй үйлчилгээ болон байгууллагаар харьцуулахад статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдахгүй байна.

Үйлчилгээний хүртээмжийг Цагдаагийн байгууллагаар үйлчлүүлэхэд гарч буй хүндрэл, ажлын цагийн тохиромжтой байдал, зорилтот бүлгийн иргэдэд үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдсэн байдал, үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай, ойлгомжтой байсан эсэх, албан хаагчдын тоо хүрэлцэж байгаа эсэх зэрэг асуудлын хүрээнд судлан гаргалаа.

### 3.3.2. Үйлчилгээний ил тод байдлын үнэлгээ

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгон байууллагын нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах, нийтлэх, шинэчлэх байдлын хэрэгжилтийг судлав.


“Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-д заасан дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгсөн байна.

Зураг 9. Ил тод байдлын шалгуур



Ийнхүү үнэлэхэд Цагдаагийн ерөнхий газар нь 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 100%-ийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Зураг 10. Ил тод байдлын үнэлгээ



Эх сурвалж: Shilen.gov.mn цахим сан. 2023.12.01-ний өдөр

Цагдаагийн байгууллагаас иргэдэд үзүүлдэг үйлчилгээний мэдээлэл ил тод, хүртээмжтэй байдаг эсэх талаар судалгаанд хамрагдагсдаас танадан судлахад үйлчилгээний талаарх мэдээллийг хангалттай авч чаддаг гэж 29.9 хувь, мэдээлэл дутуу авдаг гэж 48.9 хувь нь, мэдээлэл авч чаддаггүй гэж 21.2 хувь нь үзсэн байна.

График 15. Мэдээллийн хүртээмж



Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл нь ямар эх сурвалжаар түгээвэл илүү үр дүнтэй талаар асуухад дараах мэдээллийн эх сурвалжуудыг нэрлэсэн байсан.

Хүснэгт 6. Мэдээллийн эх сурвалж

**ЦБ мэдээ мэдээллээ ямар эх сурвалжаар түгээвэл үр дүнтэй вэ?**

- |   |  |  |
|---|--|--|
| <br>Утас мессежээр мэдээлэл өгөх   | <br>-Твиттер<br>-Брошур<br>-Сургалт зохион байгуулах                      | <br>-Сонин хэвлэл, сэтгүүл<br>-Мэдээллийн самбар   |
| <br>-Таниулан сурталчилсан хүүхэлдэйн кино хийх<br>-Бага наснаас нь хэвшүүлэх баримтжуулах | <br>-Нээлттэй хаалганы өдөрлөг<br>-Хурал цуглаан уулзалт зохион байгуулах | <br>-Телевиз<br>-Нийгмийн сүлжээ /Facebook, Twitter г.м/<br>-Радио, ФМ<br>-Интернет<br>-Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл |

### 3.4. АЛБАН ХААГЧИЙН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙ

#### 3.4.1. Албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй

Алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйг “Шударга байдал”, “Алба хаагчдын цаг баримтлах, ашиглах байдал”, “Ажилдаа хандах байдал”, “Бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал”, “Ажилтнуудын эелдэг таатай харилцаа”, “Үйлчлүүлэгчид туслахад бэлэн байдал (хандлага)” гэсэн 6 үзүүлэлтээр үнэлүүлэхэд шударга байдлын дундаж үнэлгээ 4.3, алба хаагчдын цаг баримтлах, ашиглах байдлын дундаж үнэлгээ 4.3, ажилдаа хариуцлагатай хандах байдал, бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал, ажилтнуудын эелдэг таатай харилцаа, үйлчлүүлэгчид туслахад бэлэн байдал гэсэн 4 дэд үзүүлэлтийн **дундаж үнэлгээ 4.5** байна.


График 16. Алба хаагчийн харилцааны соёл, ёс зүйн үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ



**Сахилга, хариуцлага, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар:** Энэ оны эхний хагас жилийн байдлаар иргэд, байгууллагаас цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчтай холбоотой ирүүлсэн 1982 өргөдөл, гомдлыг хүлээн авч, 2137 алба хаагчид холбогдуулан шалгасан байна.

Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал өргөдөл, гомдол 870 буюу 78.2 хувь, холбогдон шалгагдсан алба хаагч 828 буюу 63.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 11. Гомдол, мэдээллийн өсөлт



Өргөдөл, гомдолд 2137 алба хаагч холбогдон шалгагдсаны 1881 буюу 88 хувийг офицер, 351 буюу 16.4 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.

Үүнээс өргөдөл, гомдлын 44 буюу 2.2 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэх саналтай холбогдох байгууллагад шилжүүлж, 120 буюу 6.1 хувьд нь

сахилгын шийтгэл оногдуулж, 1517 буюу 76.5 хувьд цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй, 41 буюу 2.1 хувьд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдсон боловч хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл оногдуулах хугацаа өнгөрсөн үндэслэлээр хааж шийдвэрлэжээ.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас энэ оны эхний хагас жилийн байдлаар нийт 416 сахилгын зөрчилд 457 алба хаагч холбогдсоны 302 буюу 66.1 хувийг офицер, 152 буюу 33.3 хувийг ахлагч бүрэлдэхүүн, 3 буюу 0.66 хувийг энгийн ажилтан эзэлж байна.

Урд оны мөн үетэй харьцуулбал сахилгын зөрчил 225 нэгжээр буюу 35.1 хувь, алба хаагч 241 нэгжээр буюу 34.5 хувиар тус тус буурсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдах албан тушаалтанд 2023 оны эхний хагас жилд иргэдээс 11359 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 702 нэгжээр буюу 5.8 хувиар буурч, хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 239 буюу 2.1 хувь нь санал, 10970 буюу 96.6 хувь нь өргөдөл, 150 буюу 1.3 хувь нь гомдол байна.

Нийт санал, өргөдөл, гомдлын 652 буюу 5.7 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 224 буюу 0.0 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1481 буюу 13.0 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1790 буюу 15.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 297 буюу 2.6 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 6915 буюу 60.9 хувь нь бусад өргөдөл гомдол байна. Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 11255 буюу 99.1 хувийг шийдвэрлэж, 104 буюу 0.9 хувь нь ажиллагаанд байна.

Мөн хугацаанд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 2339 санал хүсэлт, гомдол, талархал, ирүүлсний 2205 буюу 94.3 хувийг шийдвэрлэж, 134 буюу 5.7 хувьд нь хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2023 оны сургалт, зөвлөгөөний хүрээнд сахилгын зөвлөгөөнийг “Сэтгэл зүйд суурилсан манлайлал” сэдэвт хэлэлцүүлгийн хэлбэрээр зохион байгуулж, хэлэлцүүлэгт 8 анги, байгууллагын удирдах ажилтнууд илтгэл мэдээлэл хийсэн байна.


Цагдаагийн ерөнхий газраас 2023 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах, алба хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулж, гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны нэгдүгээр улирлын Сахилга, ёс зүй, хариуцлагын өргөтгөсөн зөвлөгөөнийг 04 дүгээр сарын 06-ны өдөр цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 100 байршлаас 922 алба хаагч оролцсон байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг гэмт хэрэг, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, сахилгын зөрчлийг бууруулах зорилгоор “Гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилгүй хамт олон болохын төлөө” болзолт уралдааныг зохион байгуулж байна.

Нийслэлийн цагдаагийн удирдах газраас 2022 онд иргэдээс цагдаагийн алба хаагчдад холбогдуулан гаргасан гомдол мэдээлэл, сахилгын мэдээнд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн

“Эерэг хандлага-Хуульч ажиллагаа-2023” нөлөөллийн аяныг хэрэгжүүлэн ажилласнаар энэ оны эхний хагас жилд 127 сахилга, ёс зүйн зөрчилд 151 алба хаагч холбогдсон нь өмнөх оны мөн үеэс сахилга, ёс зүйн зөрчил 39 нэгжээр буюу 23.4 хувиар, алба хаагч 38 нэгж буюу 20.1 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.


График 17. Санал, гомдолтой иргэдийн хувь



### 3.5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ ОРЧИН НӨХЦӨЛИЙН ТАВ ТУХТАЙ БАЙДАЛ, ШААРДЛАГАТАЙ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХАНГАМЖ ХҮРЭЛЦЭЭ

Байгууллагын орчин нөхцөл, тав тухыг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал”, “Хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмж”, “Үйлчилгээ авах хэсэгт үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээт байдал”, “Байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц ойлгомжтой байдал” гэсэн 4 үзүүлэлтээр үнэлүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн болон үйлчилгээ авах хэсэгт үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээт байдлын дундаж үнэлгээ тус бүр 4.6, хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмжийн дундаж үнэлгээ 4.5, байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц ойлгомжтой байдлын **дундаж үнэлгээ 4.8** байна.

График 18. Байгууллагын орчин нөхцөл, тав тухын үзүүлэлтүүд, тэдгээрийн дундаж үнэлгээ



Дээрх зураглалаас харахад байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээний харагдахуйц ойлгомжтой байдал нь байх ёстой түвшиндээ, харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал, хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмж, үйлчилгээ авах хэсэгт үзгэн бал маягт зэрэг туслах зүйлсийн хүрэлцээтэй байдал зэрэг нь байх ёстой түвшиндээ хүрэхгүй байгааг харуулж байна.



# ДҮГНЭЛТ



## I ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хэрэглэгчийн үнэлгээ хийх явцад нэг талаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд болон хамтран ажиллагч байгууллагуудын төлөөлөл сайн үнэлгээ өгсөн хэдий ч анхаарах, засаж залруулах асуудал багагүй байлаа. Нөгөө талаас цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн албан үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хэр хангагдсан бэ? гэдэг асуудлыг ч мөн хамтад нь авч явах нь зүйтэй юм.

Судалгаанд хамрагдсан иргэд, хамтран ажилладаг байгууллагуудын төлөөллийн хандлагаас харахад цагдаагийн албан хаагчдын тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай машин, тоног төхөөрөмж, холбогдох бусад зардлаар дутмаг, улс төрийн нөлөөлөлд өртөх эрсдэл гарч болзошгүйг дурдаж байв.

Анхан шатанд ажиллаж буй цагдаагийн албан хаагчдын ажлын ачаалал их, цаг наргүй ажиллаж байгаагаас бүх газруудад бүрэн хүрч чадахгүй байдаг ба үүнд цаашид анхаарах шаардлагатай талаар олон оролцогч санал хэлж байлаа. Ийнхүү хэрэглэгчийн судалгааны үр дүнд үндэслэн дараах үнэлгээг өгч байна.

График 19. Үнэлгээний нийт дүн



Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн **93.02 хувь буюу 4.65 оноотой** гарсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж өндөр байгааг харуулж байгаа ба иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн өмнөх оноос **0.27 хувиар өссөн** үзүүлэлттэй байна.

Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхаарах зорилгоор түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодруулах сэтгэл ханамжийг удирдагч хүчин зүйлсийн шинжилгээг гүйцэтгэлээ.

График 20. Сэтгэл ханамжийг удирдагч хүчин зүйлсийн шинжилгээ



Иргэдийн сэтгэл ханамжийг удирдаж байгаа хүчин зүйлс нь дүрэмт хувцас, гадаад үзэмж, биеэ авч явах байдал, мэдлэг, ур чадвар, эргүүл хамгаалалтын үйл ажиллагаа, замын цагдаагийн үйл ажиллагаа, бүртгэл хяналтын төв, ажлын хуваарилалт, зохион байгуулалт, удирдлагын үйл ажиллагаа зэрэг үзүүлэлтүүд байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийг энэ хэвээр нь хадгалах нь зүйтэй. Харин бусад үзүүлэлтүүдийн хувьд дунджаас доогуур буюу сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүд юм.

График 21. GAP шинжилгээ



Энэ нь цагдаагийн албан хаагчдын хувьд хамгийн түрүүнд зан харилцаа, боловсон байдал болон ёс зүйдээ анхаарах шаардлагатай байгаа бол цагдаагийн байгууллагын хувьд өргөдөл гомдол шийдвэрлэх байдал болон мэдээллийн ил тод байдалдаа нэн тэргүүнд анхаарах, үйл ажиллагаагаа иргэдэд таниулах сурталчилах, түргэн шуурхай байдал болон үүрэг хариуцлагаа сайжруулах нь сэтгэл ханамжийг богино хугацаанд сайжруулах боломжтой хүчин зүйлс гэдгийг харуулж байна.

## ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Төрийн байгууллагын чанар, хүртээмжийн талаарх энэхүү судалгаа нь Цагдаагийн байгууллагын иргэдэд үзүүлэх үйлчилгээний талаарх үнэлэмж тул тэдний өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад анхаарах шаардлагатай билээ. Иймд алба хаагч, иргэд, байгууллагатай хийсэн ярилцлага, баримт бичгийн судалгаа болон судалгааны үр дүнд үндэслэн цаашид анхаарч ажиллах зарим санал, зөвлөмжийг өгч байна. Үүнд:

-Иргэдийн сэтгэл ханамжийг сайжруулахын тулд цагдаагийн алба хаагчдын хувьд хамгийн түрүүнд зан харилцаа, боловсон байдал болон ёс зүйдээ анхаарах шаардлагатай байгаа бол цагдаагийн байгууллагын хувьд өргөдөл гомдол шийдвэрлэх байдалдаа нэн тэргүүнд анхаарах шаардлагатай. Мөн үйл ажиллагаагаа иргэдэд таниулах сурталчилах, түргэн шуурхай байдал болон үүрэг хариуцлагаа сайжруулах нь сэтгэл ханамжийг богино хугацаанд сайжруулах боломжтой хүчин зүйлс гэж GAP шинжилгээгээр гарсан тул анхаарч ажиллах;

-2023 онд алба хаагчтай холбоотой гомдол өмнөх оны 06 сартай харьцуулахад 828-аар буюу 63.3 хувиар өссөн, мөн алба хаагчийн ёс зүйн үнэлгээ нь бусад үнэлгээнээс харьцангуй багаар үнэлэгдсэн тул алба хаагчийг соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил арга хэмжээг нэмж зохион байгуулах, сэтгэл зүйн болон өөрийгөө удирдах, хянах арга барилд тасралтгүй сургаж, хэвшүүлэх;

-Цагдаагийн алба хаагчид, ялангуяа удирдлагуудын тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх, цагдаагийн удирдлагуудын байнгын өөрчлөлт нь алба хаагчдын үр бүтээлтэй ажиллах байдалд сөргөөр нөлөөлөх, явагдаж буй үйл ажиллагааны залгамж холбоо алдагдах, иргэдийг төөрөгдөлд оруулах сөрөг үр дагавартай нь судалгаагаар гарсан тул энэ чиглэлээр бодлогын арга хэмжээ авах талаар мэдээлдэг байх.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Үндсэн хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. Дотоодын цэргийн тухай хууль
4. Төрийн албаны хууль
5. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
6. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
7. Захиргааны ерөнхий хууль
8. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
9. Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
10. Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
11. “Төрийн бодлогод хөндлөнгийн үнэлгээ хийх нь” гарын авлага 2020 он
12. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны ЦБҮАЖ код
13. Бусад холбогдох эрх зүйн актууд.